



**ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,  
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН  
ТОГТООЛ**

2021 оны 10 сарын 19 өдөр

Дугаар 522

Улаанбаатар хот

**Шалгалтын мөрөөр авах арга хэмжээний  
тухай**

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 1, 2, 66 дугаар зүйлийн 3, 4 дэх хэсгийг тус тус үндэслэн “Монголын иргэний агаарын тээвэр” төрийн өмчит хувьцаат компанийн 2021 оны санхүү, эдийн засгийн үйл ажиллагаанд хийсэн баримтын шалгалтаар нийт 3,888,794,480 (гурван тэрбум найман зуун наян найман сая долоон зуун ерэн дөрвөн мянга дөрвөн зуун наян) төгрөгийн зөрчил дутагдал илэрснийг тэмдэглээд ТОГТООХ нь:

1.Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2021 оны А-1/66 дугаар албан даалгаврын хэрэгжилт 90.5 хувь буюу “Тодорхой үр дүнд хүрсэн” гэж дүгнэсүгэй.

2.“Монголын иргэний агаарын тээвэр” төрийн өмчит хувьцаат компанийн 2021 оны санхүү, эдийн засгийн үйл ажиллагаанд хийсэн баримтын шалгалтаар илэрсэн зөрчил, дутагдлыг арилгах арга хэмжээний жагсаалтыг хавсралтаар баталсугай.

3.“Монголын иргэний агаарын тээвэр” төрийн өмчит хувьцаат компанийн Төлөөлөн удирдах зөвлөлд дараах арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

3.1.Шалгалтаар илэрсэн зөрчил, дутагдлыг арилгах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлтэд хяналт тавьж ажиллах;

3.2.Улсын төсөвт төвлөрүүлээгүй 2019 оны ногдол ашгийн өглөгийн асуудлыг шийдвэрлэх арга хэмжээ авах;

4.“Монголын иргэний агаарын тээвэр” төрийн өмчит хувьцаат компанийн Гүйцэтгэх захирал (Б.Мөнхтамир)-д санхүүгийн сахилга батыг хэвшүүлэн дотоод хяналтыг сайжруулж, дор дурдсан арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг даалгасугай:

4.1.Шалгалтын мөрөөр авах арга хэмжээний төлөвлөгөө боловсруулан хэрэгжилтийг ханган ажиллах, зөрчлийг давтан гаргахгүй байх;

4.2.Агаарын хөлөг болон төрийн өөрийн өмчийн хөдлөх эд хөрөнгө болон үл хөдлөх хөрөнгөд зар сурталчилгаа байршуулах хуулийн этгээдийг ил тод сонгон шалгаруулж, холбогдох хууль тогтоомж, журмын дагуу гэрээ байгуулж ажиллах;

4.3.Компанийн санхүүгийн тайланд бүртгэлтэй маргаантай, биетээр байхгүй үл хөдлөх хөрөнгийн асуудлыг шийдвэрлэж данс бүртгэлд тусгах;

4.4.Компанийн ашиглах эрхтэй 1.31 га, эзэмших эрхтэй 0.9 га газрын эрхийг үнэлж, санхүүгийн тайланд тусгах;

4.5.Компанийн эргэлтийн хөрөнгөд бүртгэлтэй, сүүлийн 5 жилд зарцуулагдаагүй бараа материалыг эргэлтэд оруулж Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15.1.6 дахь заалтын хэрэгжилтийг хангаж ажиллах;

4.6.Бараа материалын тооллогын дүнгээр 2012-2017 онд элэгдэж дутагдсан сав хэрэглэлийг холбогдох хууль тогтоомжийн дагуу данснаас

4.7.Компанийн ажилтнуудад олгосон цалингийн зээл болох 317,767,950 (гурван зуун арван долоон сая долоон зуун жаран долоон мянга есөн зуун тавин) төгрөгийн авлагыг 2024 оны 1 дүгээр улиралд багтаан барагдуулах;

4.8.Худалдан авах ажиллагаанд Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль, журмын хэрэгжилтийг хангаж ажиллах, зөрчлийг таслан зогсоох;

4.9.Шалгалтаар илэрсэн зөрчил, дутагдлыг арилгах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлтийг 2024 оны 2 дугаар улиралд багтаан Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлэх.

5.“Монголын иргэний агаарын тээвэр” төрийн өмчит хувьцаат компанийн дүрмийг шинэчлэн эрх бүхий этгээдээр батлуулахыг Төрийн өмчийн удирдлага, зохицуулалтын хэлтэс (Ц.Баяр-Эрдэнэ)-т үүрэг болгосугай.

6.Гаалийн болон нэмүү өртгийн албан татварын хөнгөлөлт, чөлөөлөлтийн жагсаалтад тусгагдаагүй агаарын хөлгийн сэлбэг хэрэгсэл, түүний дагалдах багаж, тоног төхөөрөмжийг үйлдвэрлэгчийн каталогийг үндэслэн татвар ногдуулж байх талаар эрх бүхий байгууллагад хандаж, “Монголын иргэний агаарын тээвэр” төрийн өмчит хувьцаат компанид дэмжлэг үзүүлж ажиллахыг Төрийн өмчийн удирдлага, зохицуулалтын хэлтэс (Ц.Баяр-Эрдэнэ)-т даалгасугай.

7.Энэхүү тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн хяналт шалгалтын хэлтэс (Ц.Түвшинзаяа)-т даалгасугай.

ДАРГА

ТӨРИЙН ӨМЧИЙН ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН  
ХЭЛТСИЙН ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

Ц.ТҮВШИНЗАЯА

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын  
2023 оны ... дугаар сарын ...-ны өдрийн  
... дугаар тогтоолын хавсралт

“МОНГОЛЫН ИРГЭНИЙ АГААРЫН ТЭЭВЭР” ТӨРИЙН ӨМЧИТ ХУВЬЦААТ  
КОМПАНИД ХИЙСЭН ШАЛГАЛТААР ИЛЭРСЭН ЗӨРЧИЛ,  
ДУТАГДЛЫГ АРИЛГАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ЖАГСААЛТ

Д/д	Шалгалтаар илэрсэн зөрчил, дутагдлын утга	Үнийн дүн (сая төгрөг)	Зөрчигдсэн эрхзүйн акт	Цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний санал
1	Байгууллагын нэр дээр тамирчдыг цалинжуулсан	76.5	Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 дэх заалт, Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоол	Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах
2	Ажилтнуудад цалингийн урьдчилгаа хяналтгүй олгосон	317.8	Төсвийн тухай хууль, Байгууллагын дотоод журам	Урьдчилгааг журмын дагуу олгож авлагыг барагдуулах
3	Ахмадын сангийн журмыг зөрчиж нэмэгдэл тэтгэвэр олгосон	206.4	“Ахмадын сан байгуулах ажиглуулах журам”-ын 3.1.1 дэх заалт	Зөрчлийг давтан гаргахгүй байх, журам шинэчлэх
4	Хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд тусгагдаагүй үндсэн хөрөнгө бэлтгэсэн	120.7	ТБОНӨТ хуулийн 11.8 дахь заалт, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2020 оны 612 дугаар тогтоол	Хөрөнгө оруулалтын батлагдсан төлөвлөгөөнд тусгаагүй, төлөвлөөгүй хөрөнгө бэлтгэхгүй байх
5	Үндсэн хөрөнгө данснаас гадуур бүртгэсэн, шилжүүлж данснаас хасах шийдвэрийн хэрэгжилтийг зөрүүтэй тайлагнасан	1,180.8	Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2021 оны 159, 475 дүгээр тогтоол, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль	Хөрөнгийн хөдөлгөөнийг шийдвэр, нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн дагуу хийж байх
6	Бусдаас байр талбай түрээслэхдээ 1 м.кв талбайн түрээсийн төлбөрийн тогтоосон дээд хязгаараас хэтрүүлсэн	578.4	Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2018 оны 01 дүгээр тэмдэглэл	Шийдвэрийг мөрдөж ажиллах, зөвшөөрөл авч ажиллах
7	Худалдан авах ажиллагаанд тендер шалгаруулалтын журмыг мөрдөөгүй	1,408.1	“ТБОНӨБАУХАТ хуулийн 8.4, 8.5 дахь заалт	Тендер шалгаруулалтын журмыг мөрдөж ажиллах
Нийт дүн:		3,888.8 (гурван тэрбум найман зуун наян найман сая долоон зуун ерэн дөрвөн мянга дөрвөн зуун наян)		